

1.1. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН АЛСЫН ХАРАА

Биеийн тамир, спортын газрын алсын хараа нь Төв аймгийн иргэд эрүүл чийрэг байхын тулд биеийн тамирын дасгал, хөдөлгөөнийг өдөр тутмын хэрэглээ болгоход шаардлагатай орчин нөхцлийг бүрдүүлэх явдал мөн.

1.2. ЭРХЭМ ЗОРИЛГО, ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ:

Хүн амыг биеийн тамир, спортоор хичээллэх нийгэм, сэтгэл зүй, материаллаг орчин нөхцлийг бүрдүүлэх замаар эрүүл чийрэг байлгах, улмаар тамирчдын амжилтыг тив, дэлхий, олимпийн түвшинд хүргэхэд оршино.

Энэхүү эрхэм зорилгыг хангаж ажиллахын тулд дараахь үндсэн зарчмыг үйл ажиллагаандаа эрхэмлэнэ.

- Бодлого, чиглэлийг оновчтой, зөв тодорхойлох, биеийн тамир, спортыг хөгжүүлэх хэтийн болон ойрын зорилт, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, бодит хэрэгжих боломжтой, үр дүнг тооцож дүгнэх зарчмыг баримтлах
- Ардчилсан ёс, шудрага ёс, эрх чөлөө, тэгш байдал, хууль дээдлэх ил тод, нээлттэй байдлыг эрхэмлэх
- Хэрэглэгчдэд нийцсэн биеийн тамир, спортын ажил, үйлчилгээг хамгийн хямд, хүртээмжтэй хангах, авъяас чадварыг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

1.3. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ:

БТСГ-ын стратегийн зорилтыг зөв тодорхойлохын тулд өөрийн дотоод болон гадаад хүчин зүйлүүдийг “ SWOT “ шинжилгээний аргаар үнэлж, байгууллагын давуу болон сул тал, учирч болох эрсдэл, бэрхшээл боломж нөхцлөө тодорхойлов.

	Давуу тал	Сул тал
Догоод орчин	<ul style="list-style-type: none"> - БТСГ-ын үйл ажиллагааны стратеги зорилт, ажлын байрны тодорхойлолт гарсан - БТС-ын байгууллагын өмч хөрөнгө, санхүү хүний нөөцийн чадавхи зохих түвшинд хүрсэн - Байгууллага төрийн захиргааны байгууллагын шинэ бүтэц, зохион байгуулалтаар ажиллаж байна. - БТС-ыг хөгжүүлэхэд байгууллага, иргэдийн идэвхитэй хөдөлгөөн өрнүүлэх - Өөрийн байр, спортын заал, зохих хэмжээний тоног төхөөрөмжтэй - “БТС-ын тухай”, “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулиудад гарч эрх зүйн орчны эхлэл тавигдсан - БТС-ын байгууллагын тогтолцоо, төв, орон нутгийн захирааны нэгж даган бий болсон - Хөрш ОХУ, БНХАУ болон гадаад бусад орны БТ, спортын байгууллагатай холбоо тогтоон хамтран ажиллах, туршлага судлах - Хүн ам болон аж ахуйн нэгж байгууллагуудын дунд биеийн тамир, спортоор хичээллэх сонирхол сэргэсэн - Хувийн хэвшлийн БТС-ын байгууллагууд бий болж байна. 	<ul style="list-style-type: none"> - БТС-ын салбарын урт ба дунд хугацааны бодлого, стратеги үгүйлэгдэж байна. -БТС-ын салбарт стандартчилал байхгүй - Сумаас эхлээд салбарын бүх шатны байгууллагын санхүүгийн нөөц, орон тоо хязгаарлагдмал - Бодлого, хөтөлбөрөө хэрэгжүүлэх боломж хөрөнгө мөнгө хязгаарлагдмал - Ажилчдын цалин хөлс, ажиллах нөхцөл, мэдлэг мэргэшлээ дээшлүүлэх сургалт, нийгмийн асуудлаа шийдвэрлэх боломж, тогтвортой ажиллах баталгаа хангалтгүй - Салбарын хүний нөөцийн чадавхи сул - Салбарын хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа муу - Салбарын эдийн засгийн харилцаа сул -Хүн амын амжиргааны түвшин доогуур байна - Иргэд БТС-р хичээллэх нийгмийн орчин нөхцөл хангалтгүй, хөрөнгө санхүүгийн хомсдолтой байгаа - Засгийн газрын төсвийн өчүүхэн хувийг БТС-ын зардал эзэлж байна. - БТС-ыг дэмжих татварын болон бусад хууль эрх зүйн орчин бүрдээгүй - Хүн ам тархай бутархай суурьшсан, дэд бүтцийн хөгжил сул
Галаад орчин	Боломж	Бэрхшээл

1.4.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ:

БТСГ нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ.

Стратегийн зорилт 1: - БТСГ-ын удирдлага, санхүү эдийн засгийн төлөвлөлтийг боловсронгуй болгох

Стратегийн зорилт 2: - “Биеийн тамир спортын тухай” хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, хүний нөөцийн хөгжлийг бүрдүүлэх

Стратегийн зорилт 3:- БТС-ын хөгжих нийгмийн орчин /заал, талбай/, спортын барилга байгууламжийг нэмэгдүүлэх, өмчлөх, ашиглахад хяналт тавьж, үнэлэх

Стратегийн зорилт 4:- БТС-ын удирдлага, чанар, үр дүнг сайжруулахад статистик дүн мэдээ, мэдээлэл, сурталчилгааг эрчимтэй зохион байгуулах

Стратегийн зорилт 5: - Спортын салбарын бодлого, түүний хэрэгжилтийг зохицуулах

Стратегийн зорилт 6:- НБТ-ын бодлогын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх

Стратегийн зорилт 7:- Спортын олон талт гадаад харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэн өргөжүүлэх

2. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

2.1. 2016-2020 ОНЫ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ:

2.1.1.БТС-ын хөгжлийн эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар:

НБТ-их спортыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулан гаргах

Тоо хэмжээ, хугацаа:

БТС-ыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд 1 бүтээгдэхүүн орно. НБТ-их спортыг хөгжүүлэх төлөвлөгөөг батлуулан гаргах. 2017 онд

Чанар:

Төлөвлөгөөг боловсруулахдаа дараахь чанарын шаардлага тавина.

- Үндэсний, Хүүхдийн, Оюутны, Бүх ард түмний наадмуудыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, өсвөрийн шигшээ баг хичээллэх журмын талаар Аймгийн ЗД болон ИТХ-ын шийдвэрүүдийг гаргуулах

- “Биеийн тамир спортын тухай” хууль, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилттой нийцсэн байх

- БСШУСЯ, Аймгийн төсвийн хөрөнгө, санхүүгийн нөөц, төсөвт захирагдах

- Албан бичиг баримтын стандартын шаардлага хангах

2.1.2. Биеийн тамир, спортын хөгжлийн материаллаг орчин нөхцлийг бүрдүүлэх талаар:

- Сум, ЕБС-ын спортын материаллаг баазыг бэхжүүлэн, БТ-ын гадаа талбай, гүйлтийн замын маршруттай болгох

- Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд БТ-ын хамтлагийг байгуулан чийрэгжүүлэлтийн танхим байгуулах

- Эрдэнэсант, Аргалант, Баянцогт сумдад спортын заал ашиглалтанд орно

- БТС-ын тоног төхөөрөмж, хэрэглэл материалын хангалтыг сайжруулах, өөрсдөө хийх санаачлагыг дэмжих, хүртээмжийг нэмэгдүүлэх

Тоо хэмжээ, хугацаа:

- 27 сум, 31 сургуулийн гадаа талбайн тохижилтыг сайжруулах, НЭМ-ийн талбай болгох,

- Мөнгөнморьт, Батсүмбэр аялалын, Баян, Угтаалцайдам сумд гүйлт алхалтын маршрут, Зуунмод суманд дугуйн замтай болгох

Чанар:

- Спортын ордны эрүүл ахуйн орчин нөхцлийг орчин үеийн шаардлаганд нийцүүлэх
- Хүний нас, биеийн онцлогт тохирсон орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах

Өртөг: - 2.253,0 сая төгрөг

2.1.3. Хүн амын дунд зохиох БТС-ын ажил үйлчилгээний талаар:

- Нийтийг хамарсан бүх нийтийн гүйлт, явган аялалаас “Хүн хөдөлгөөн-хөгжил” уриан дор БТ-ын нэгдсэн ажил үйлчилгээг жил 4-8 төрлөөр зохион явуулна.

- Хүний биеийн чийрэгжилтийн түвшинг жил бүр ЕБС-ын сурагчид, насанд хүрэгчдээс авч 2020 онд 10 хүртэлх хувиар ахиулах болно

- Жил бүр өсвөр үе 12, насанд хүрэгчид 8, ахмад 3-аас доошгүй төрлөөр ААШТ-ийг зохион явуулна.

- Улс болон олон улсын тэмцээн уралдаанд тамирчдын бэлтгэлжилтийг хангуулан оролцуулах, аймагтаа жилд 2-оос доошгүй төрлийн УАШТ-ийг зохион байгуулах

- Өсвөрийн шигшээ багийг спортын 12 төрлөөр байгуулж улс, ОУ-ын тэмцээнд өрсөлдөхүйц тамирчиг бэлтгэн гаргана.

- Бүх нийтийг биеийн идэвхитэй дасгал хөдөлгөөнөөр эрүүл мэндээ хамгаалдаг, сонирхсон спортын төрлөөр тогтмол хичээллэн амжилт гаргах нөхцөл бололцоог бүрдүүлнэ.

-

- 2018 онд Үндэсний спортын их наадам

- 2019 онд Хүүхдийн спортын их наадмыг зохион байгуулах, оролцох

- 2020 онд Аймгийн Бүх ард түмний спортын их наадам

Тоо хэмжээ, хугацаа:

- Дээрхи наадмуудыг тухайн жилд зохион явуулна.

Чанар:

- Улсын хөрөнгө, санхүүг үр ашигтай хэмнэлттэй зохицуулах
- Хүн амын БТС-р хичээллэх идэвхи санаачлагыг дэмжиж туслах
- Тамирчдын спортын ур чадварыг дээшлүүлж олон улсын түвшинд хүрч өрсөлдөх хэмжээнд хүргэх
- БТС-ыг иргэдийн эрүүл мэндийг хамгаалах байнгын ажил, үйлчилгээ болгох

Өртөг: - 901.2 сая төгрөг

3. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

БТСГ нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж, үндсэн зорилтоо ханган биелүүлэхэд МУ-ын Засгийн газрын, МУ-ын ЗГ-ын 2014 оны 03-р сарын 07-ны өдрийн 75-р тогтоолыг үндэслэн байгууллагын ажилтан албан хаагчдын цалин, нэмэгдлийг олгож байна.

4. ХЯНАЛТЫН МЕХАНИЗМ

БТСГ-нь удирдлагын зүгээс гарах шийдвэр, эдийн засгийн төлөвлөлт, өөрийн үйл ажиллагаа, санхүү бүртгэл тооцоо, төсвийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, зарцуулалтанд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлнэ. Энэхүү хяналт нь төрийн, олон нийтийн, хамт олны зүгээс хэрэгжих ба эцсийн шийдвэр нь МУ-ын Иргэний болон Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжинд захирагдана.

4.1. САНХҮҮГИЙН ХЯНАЛТ

Төсвийн хөрөнгийн үр ашиг, ашиглалтанд төрийн аудит, мэргэжлийн хяналтын газар, татвар, холбогдох бусад газрууд болон дотоод хяналтыг хэрэгжүүлнэ. Төрийн аудит нь төсвийн хөрөнгийн үр ашиг, ашиглалтанд тавих хяналт, шалгалтыг байгууллагын улирал, жилийн санхүүгийн тайланд аудит хийх замаар санхүү тайлан бүртгэлээр болон биет хэлбэрээр явуулна.

Мэргэжлийн хяналтын шалгалт нь мэдээллийг хянан баталгаажуулах, төрийн өмчийн хохирлыг тогтоох хэлбэрээр явуулна. Татварын хяналт нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, албан татварын бүрдүүлэлт, төлөлтийг шалгаж баталгаажуулна.

Хяналтын системийн үндэс нь үйл ажиллагааны дотоод хяналт бөгөөд энэхүү үйл ажиллагааг хэвийн явуулахад Ерөнхий менежер буюу санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаа, БТСГ-ын даргын шийдвэрээр байгуулагдсан байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл” хэрэгжүүлэх бөгөөд өөрийн үйл ажиллагаа, гаргасан шийдвэрээ Даргын зөвлөлийн хуралд танилцуулж эцсийн шийдвэрийг гаргана.

4.2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ

Үйл ажиллагааны хяналтыг удирдлагын, хамт олны, олон нийтийн хэлбэрээр явуулна.

Удирдлагын зүгээс тавих хяналтыг байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн биелэлтийг хангахад чиглүүлнэ. Ерөнхий менежер нэгжийн дарга, ажилтан нэг бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллах ба гэрээний үндсэн хэсэг нь энэхүү төлөвлөгөөнд тодорхойлсон төсвийн жилд нийлүүлэх ажил, үйлчилгээ байна. БТСГ-ын үйл ажиллагаанд тавих хяналт нь төсвийн шууд захирагч, албадын гэсэн 2 түвшинтэй байна. Албадын дарга нарын саналыг харгалзан ажилтнуудын хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хагас бүтэн жилээр, төсвийн шууд захирагч дүгнэнэ. Аймгийн ЗД буюу төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг хагас бүтэн жилээр тус тус дүгнэнэ.

Хамт олны хяналтнь байгууллагын нийт ажилтан албан хаагчдын зүгээс байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, хувь хүний зөрчил дутагдалыг арилгах, хэлбэрээр тухайн байгууллагын харилцааг зохицуулахад оршино. Энэхүү хяналт нь байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хамт олны бие бидээ тавьж буй ажлын шаардлага, зөвлөгөөг, санал, шүүмжлэл, хурал цуглааны хэлбэрээр илэрч байдаг.

4.3.УДИРДЛАГЫН ЗҮГЭС ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦАД ТАВИХ ХЯНАЛТ

БТСГ-ын даргаас шийдвэр, тушаал гаргахад мэргэжилтнүүдээс ажлын байрны чиг үүргийн дагуу төслийг бэлтгэж, уг шийдвэрийн үндэслэлийг боловсронгуй болгох, хууль тогтоомжинд нийцүүлэхэд нь зөвлөгөө өгч дэмжлэг туслалцаа үзүүлнэ.БТС-ын салбарт хэм хэмжээ тогтоох, хөрөнгө зарцуулах, төрийн албан хаагчийн асуудлыг шийдэх тушаалын төслийг дээр дурьдсан журмаар бэлтгэж холбогдох мэргэжилтэн нэгжийн дарга гарын үсэг зурж шийдвэрийн ил тод байдлыг хангана.Мөн зарим асуудлаар мэргэжлийн хүмүүс, эрдэмтэн-судлаачид, байгууллага, иргэдийн санал авах, ажлын хэсэг байгуулан ажиллуулах замаар шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоог өргөтгөж дэмжлэг үзүүлнэ.

4.4.ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТЭНД ТАВИХ ХЯНАЛТ

БТС-ын талаар УИХ, Ерөнхийлөгч, ЗГ, ЗД, ИТХ-аас гарсан тогтоол шийдвэр, захирамж, хугацаатай өгсөн үүргийг нэг бүрчлэн бүртгэж, хяналтанд авч, түүний биелэлтийг хангах ажлыг зохион байгуулж, үр дүнг дүгнэн биелэлтийн тайлан мэдээг холбогдох газруудад улирал, хагас, бүтэн жилээр гаргаж байна.

Даргын тушаалаар хугацаатай өгөгдсөн үүргийг хяналтанд авч, биелэлтийг сар, улирлаар гарган дүгнэж, тасарсан буюу, хугацаа хэтэрсэн асуудлыг дэргэ болон мэргэжилтнүүдэд танилцуулж биелэлтийг хангах арга хэмжээ авна.

5. ТӨСӨВЛӨСӨН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.

5.1.ТӨСӨВЛӨСӨН САНХҮҮГИЙ ТАЙЛАНГИЙН БОДИТ БАЙДЛЫН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

БТСГ нь улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдөн ажиллаж байна.

БТС-ын салбарын санхүүгийн механизмыг боловсронгуй болгох, НББ-ийг олон улсын нэгдсэн стандартад оруулах, бүртгэлийг сайжруулахад анхаарч ажилласанаар эдийн засаг, санхүү, НББ, төсвийн төслийн нэгдсэн бодлого, удирдлага, төлөвлөлтөөр хангагдаж байна.БТСГ нь үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан урсгал ба төвлөрсөн хөрөнгө оруулалтын гэсэн хэлбэрээр санхүүжилт авч зарцуулалтанд хяналт тавьж ажиллаж байна.

Бүртгэлийн тусгай бодлогууд:

Төсвийн хөрөнгийн санхүүжилтийн шинэ зарчимд шилжсэнтэй холбогдуулан өөрийн ашиглаж буй хөрөнгийн элэгдлийг тооцож, ирээдүйн хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлох үүднээс үндсэн хөрөнгийн элэгдлийг ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолыг баримтлан тооцсон.

Үндсэн анхны өртөг буюу түүхэн өртөгөөр нь бүртгэсэн.Элэгдлийг шулуун шугамын аргаар тооцсон бөгөөд гол гол үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход дараах хугацааг баримтлалаа.

- Тавилга эд хогшил 10 жил
- Компьютер техник хэрэгсэл 4 жил

- Машин тээврийн хэрэгсэл 6 жил
- Барилга 36 жил

Ажиллагсадын жилийн амралтыг ажилтан бүрээр хуримтлуулан тооцсон ба олгохоор тооцоолсон цалингийн дүнг үндэслэн тооцож байна.

Бүтээгдэхүүний өртгийн тооцоололт:

Ерөнхий менежер нийлүүлэх бүтээгдэхүүний өртөгийг дараах байдлаар төсөвлөнө. Үүнд:

1. Орцод суурилсан төсвөөс хяналтанд байгаа тодорхойлох боломжтой зардлуудыг шууд, боломжгүй зардлуудыг шууд бус зардлаар тус тус ангилаж нэгжүүдээс нийлүүлж буй бүтээгдэхүүний өртөгийг хянах бололцоог олгох төдийгүй зардал хэтэрсэн эсвэл нэмэлт гарсан шалтгааныг тодруулах боломжтой болох юм.
2. Бүтээгдэхүүн тус бүрийг нийлүүлэхэд зарцуулах хүн өдрийг хуанлийн ажлын өдрөөр тооцно.
3. Нэгж бүрээр тодорхойлсон хүн өдрийн төсөвт үндэслэн шууд зардлыг үндсэн бүтээгдэхүүнд хувиарлав. Үндсэн бүтээгдэхүүний зардлыг хүн өдөрт суурилна.
4. Хувиарласнаар тухайн газар хэлтэс болон нэгжүүдэд ажиллаж буй хүн бүрийн тухайн бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд оролцож буй оролцооноос хамаарч тухайн бүтээгдэхүүн хичнээн төгрөгийн өртөгтэйгээр бүрдэж байгааг тодорхойлох бололцоотой болж байгаа юм.
5. Шууд бус зардлыг хувиарлах хувиарлалтын II шатлалт аргыг ашиглан нийт шууд бус зардлыг зардлын тодорхой сууриудыг ашиглан хувиарлав. Тухайлбал үндсэн хөрөнгийн элэгдлийг эзэмшиж буй хөрөнгийн дүнд ном хэвлэл, аж ахуйн материалын зардал зэргийг газар, хэлтэс бүрт ажиллаж буй хүний тоонд цахилгаан, дулаан, уур усны зардлыг тус бүрийн ашиглаж буй өрөө тасалгаа түүний талбайн хэмжээнд суурилуулан хувиарлах болно.
6. Нэгжүүдэд хувиарлагдсан шууд бус зардлыг хүн өрдийн төсөвт үндэслэн үндсэн бүтээгдэхүүнд хувиарлана.
7. Бүтээгдэхүүн тус бүр хувиарлагдсан шууд ба шууд бус зардлын нийлбэрээр тухайн жилд нийлүүлэх бүтээгдэхүүн тус бүрийн бүрэн өртөгийг тодорхойлно.
8. Засварын болон дотоодын бүтээгдэхүүнд өртөг хувиарлахгүй учир нийт хүн өдрийн төсвөөр гарсан шууд бус хөдөлмөрийг нэгжийн өртөгт тархаан, шингээх зорилгоор хувиарлалтын шат дараалан хувиарлах аргыг ашиглаж хүн өдрийг суурь болгон үндсэн бүтээгдэхүүнд хувиарлана.

Санхүүгийн үйл ажиллагааны зорилго ба үзүүлэлтүүд:

БТСГ- нь санхүүгийн үйл ажиллагаандаа доорхи зорилтыг дэвшүүлэн ажиллахаар дэвшүүлж байна. Үүнд:

- НББ-ийг олон улсын стандарттай нийцүүлэн НББ-ийн тухай хуулийн 17-р зүүлийн 2 дахь заалтыг үндэслэн санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж стандарт, дүрэм, журам, зааварт нийцсэн НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж ажиллах

- Сангийн Яамнаас боловсруулан гаргасан аж ахуйн нэгж байгууллагад мөрдөх НББ-ийн маягт, заавар, аргачлалыг ашиглах, өөрийн байгууллагын санхүү бүртгэлд нэвтрүүлэх талаар ерөнхий, /ахлах/ нягтлан бодогч нарыг сургалтанд хамруулах
- Батлагдсан төсвийн дагуу бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг үндэслэн төсвийн зарлагыг сар, улирлын хувиараар батлан зүйл ангилалаар зардлын бүртгэлийг хөтлөж хэвшүүлэх

**БТСГ-ын дунд хугацааны төсвийн төслийн
бодлогын мэдэгдэл.**

БТСГ-ыг хөгжүүлэх үндсэн зорилтыг үйл ажиллагааны төсвийн төсөлтэй уялдуулан 2017-2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт суурилсан дунд хугацааны төсвийн төслийн бодлогыг мэдэгдлийн тоо, чанар, үр ашгийн үзүүлэлтээр тодорхойлон гаргалаа.

Хөтөлбөрт суурилсан дунд хугацааны төсвийн төслийн бодлогын мэдэгдэл:

Хөтөлбөр	БТС-ын үйл ажиллагаа	Чанарын үзүүлэлт	Тоон үзүүлэлт
Хөтөлбөрийн тодорхойлолт	Хүн ам, НБТ, спортоор хичээллэх нийгмийн материаллаг болон сэтгэл зүйн орчин бүрдүүлэх, тэдний эрүүл мэнд, бие бялдрын боловсролыг дээшлүүлэх зорилгоор БТС-ыг нийгмийн бодлогын тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх, спортын уралдаан тэмцээнд бэлтгэх, зохион байгуулах, оролцох үйл ажиллагаа хамрагдана.		
Хөтөлбөрийн зорилго	Иргэдийн БТС-оор тогтмол хичээллэх орчин бүрдүүлж тэдэнд эрүүл аж төрөх, бие бялдрын боловсрол мэдлэгээ байынга дээшлүүлэх хүсэл тэмүүллийг төлөвшүүлэх, байгууллага хамт олны эрэлт хэрэгцээг хангах - Олимп, дэлхий, тив, ОУ, УАШТ-нд аймгийн баг тамирчдыг бэлтгэн оролцуулах нөхцөл бололцоог бүрдүүлэн их спортыг хөгжүүлж амжилт гаргаж Аймаг орноо сурталчилах	- Хүн амын НБТ-спортоор хичээллэх орчин нөхцлийг бий болгож заал, талбай, хэрэгсэл, материалын хүрэлцээ сайжирна - Хүн ам эрүүлжин өвчлөл багасана - Тамирчдын ур чадвар сайжирна	-БТС-оор хичээллэгсэд хүн амын 40 %-д хүрнэ -Жилд УАШ болон олон улсын тэмцээн тамирчдаа оролцуулна
2017 оны зорилт	-НБТ-ыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, БТС-ын ажил үйлчилгээний стандартыг гаргах - Хүн амыг БТС-оор хичээллэх орчин үеийн стандартад нийцсэн спортын заал, талбай, тоног төхөөрөмжийн хангамж төлөвлөлтийг	-Сум, ЕБС, аж ахуйн нэгж, байгууллагад нэгдсэн аргачлал стандарттай болж НБТ-спортын ажил үйлчилгээг өргөснө. - БТС-ын тоног төхөөрөмж, хэрэглэл материалын тоо, чанар нэмэгдэж, хичээллэгчдийн	-БТС-ын салбарын хэмжээнд үлй ажиллагааны нэгдсэн стандарт нэмэгдэнэ - Заал талбай тоног төхөөрөмжийн тоо нэмэгдэнэ - Улс болон, олон улсын тэмцээнд оролцох спортын

	<p>боловсронгуй болгох - Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааны хяналтын тогтолцоо бүрдүүлэн тамирчид дасгалжуулагчдын ажиллах нөхцлийг сайжруулах</p>	<p>нөхцөл бололцоо сайжирна. - Тамирчид, дасгалжуулагчдын ажиллах орчин сайжирч, бэлтгэл сургуулилтын чанар дээшилнэ.</p>	<p>төрөл, тамирчдын тоо өснө</p>
Үр ашиг	<p>БТС-ын салбарыг хөгжүүлэх зорилт төлөвлөгөө хэрэгжин иргэдийн БТС-оор хичээллэх таатай орчин бий болж хүн амын чийрэгжүүлэлтийн түвшин дээшилж их спортоор хичээллэгсэдийн тоо өсөж, тамирчдын үр чадварт тоо чанарын өөрчлөлт гарна.</p>		
2018 оны зорилт	<p>-НБТ-ыг хөгжүүлэх ажил үйлчилгээнд өргөн олныг хамруулах замаар тэдний бие бялдрын боловсролыг дээшлүүлэх, чийрэгжилтийн түвшинд хяналт шинжилгээ хийх тогтолцоотой болох - БТС-ын сургалттай сургууль байгуулах бэлтгэл ажлыг хангах - Тамирчдын сургалт дасгалжуулалтыг спортын ангаах ухаан, шинжилгээ судалгааны үндэстэй, цогц үйл ажиллагаа болгох - Үндэсний спортын их наадмыг зохион байгуулах, оролцоно</p>	<p>-Хүн амын бие бялдрын хөгжилд чийрэгжилтийн түвшингийн нэгдсэн судалгаатай болно. - Тамирчид бэлтгэл дасгалжуулалтын онол арга зүйн нэгдсэн гарын авлагатай болж бэлтгэлжилтийн түвшин нэмэгдэнэ. - Зуунмод 4-р сургууль чөлөөт бөх - Заамар Бокс - Жаргалант Цана төрөлжсөн сургалттай анги хичээллүүлэх</p>	<p>-Сумдын НБТ-ын ажил үйлчилгээнд хяналт шинжилгээ үнэлгээ явуулдаг болно - БТС-ын уралдаан тэмцээний тогтолцоо бий болгож УАШТ-нд тамирчдын үзүүлэх амжилт өснө. - Үндэсний спортын уламжлал, өв соёлыг дэлгэрүүлэн үндэсний спортын хичээллэгчдийн тоо өснө.</p>
Үр ашиг	<p>БТС-ын салбарын удирдлага төлөвлөлт, системтэй болж иргэдэд үзүүлэх НБТ-ын үйлчилгээний тогтолцоо бүрдэн хүн амын бие бялдар, эрүүл мэндийн түвшин дээшилж хүн амын дундаж наслалт нэмэгдэнэ.Их спортоор хичээллэгсэдийн эрх зүйн болон орчны нэгдсэн тогтолцоотой болж уралдаан тэмцээний тоо, чанар дээшилж, тамирчдын амжилт нэмэгдэнэ</p>		
2019 оны зорилт	<p>-БТС-ын хууль шинэчлэгдэн хэрэгжиж эхэлнэ. - Аймгийн төвд спортын дунд сургууль байгуулах - Хүүхдийн спортын наадам зохион явуулах, оролцох</p>	<p>-БТС-ын заал танхим, хэрэгсэл материал, ажил үйлчилгээний стандарт бий болно - 4-р сургуульд хөнгөн атлетик, жү-догийн анги нээж хичээллэх, өсвөрийн шигшээ багийн сургалтын чанар сайжирна.</p>	<p>- Сумдад биеийн тамирын арга зүйчтэй болно - Спортоор хичээллэгчдийн тоо 8-10 %-иар өснө</p>

Үр ашиг	МУ-ын БТС-ын хууль хүн амын бие бялдрын чийрэгжилтийн түвшин 5-8 %-иар дээшилж, өвчлөл 2-3 %-иар буурна.Бүх сумдад НБТ-ын арга зүйчтэй болно.Нэг хүнд зарцуулах БТС-ын зардал нэмэгдэж спортоор хичээллэгчдийн тоо өсч, УА болон олон улсын тэмцээнд оролцох тамирчдын ур чадвар дээшлэн аймгийн нэр хүнд өснө		
2020 оны зорилт	-БТС-ыг хөгжүүлэх бодлого, чиглэлийг гарган ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт оруулах - МБАТ-ний спортын наадмыг зохион байгуулан явуулах, оролцох	-Иргэдийн БТС-оор хичээллэх орчин нөхцөл сайжирна	-БТС-ын хөгжлийн эрх зүйн баримт бичиг бий болно
Үр ашиг	Нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан боловсруулсан БТС-ын бодлого хэрэгжиж, орон нутагт БТС-ын орчин сайжирч, тамирчдын гадаадын тэмцээн уралдаанд оролцох бэлтгэл сургуулилт, санхүүжилтийн тогтолцоо бүрдэнэ		

5.2. Төсөвлөсөн санхүүгийн тайлангийн бодит байдлын мэдэгдэл

БТСГ-ын ерөнхий менежер Га.Лхагвасүрэн, ерөнхий нягтлан бодогч Д.Батдулам бид манай байгууллагын 2017, 2018, 2019, 2020 оны төсөвлөсөн санхүүгийн тайлант хугацааны үр дүн санхүүгийн байдлыг үнэн зөв бүрэн тусгасан болохыг батлаж байна.Үүнд:

1. Бүх ажил үйлчилгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн НББ, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол харьцангуй зөв хийгдсэн
3. Байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн бүхийл үйл явцыг иж бүрэн хамарсан
4. Тайлант үеийн үр дүнг өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгагдаагүй мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй
5. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр боидт үнээр үнэлэгдсэн
6. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны эзэмшилд байдаг бөгөөд орхигдсон зүйл байхгүй.

6. ӨМЧЛӨЛИЙН БУСАД ЗОРИЛТУУД

БТСГ төрийн бодлого шийдвэрийн биелэлт, стратегийн зорилтуудыг ханган биелүүлэхэд байгууллагын хэмжээнд ашиглагдаж байгаа төрийн өмч хөрөнгийн нөөцийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, үр ашигийг нэмэгдүүлэх, өөрчлөх, сайжруулах, эд хөрөнгө худалдан авах, актлах, худалдах, хөрөнгө оруулалт хийх зэрэг үйл ажиллагааг төсвийн тухай хууль, Төрийн өмчийн тухай хуулийг баримтлан явуулж байгаа ба энэ нь төрийн өмч хөрөнгийн үр ашигийг нэмэгдүүлэх эрсдлийг багасгах зорилтыг хангана.

Байгууллагын зорилт төрийн үйлчилгээний шуурхай байдал түүний үр нөлөөг дээшлүүлэх, хүний нөөц, эд хөрөнгө болон санхүүгийн нөөцийг бүрдүүлэх учирч болох эрсдлийг удирдах үүднээс 2017-2020 онд хөгжлийн талаар дор дурьдсан зорилтуудыг дэвшүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

Өмчлөлийн зорилт 1. Байгууллагын бүтэц зохион байгуулалт, нэгжийн ажлын байрны чиг үүргийг оновчтой болгоно.

Энэхүү зорилтын хүрээнд дор дурьдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1. Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн батлуулах
2. БТСГ зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны стратегийг батлаж мөрдүүлнэ
3. Албан хаагчдын ажил үүргийн давхардал, ачаалалыг судалж, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батална.

Өмчлөлийн зорилт 2. Төрийн албан хаагч, ажиллагчдын чадавхийг дээшлүүлж, ажлын чанар үр нөлөөг дээшлүүлнэ.

Энэхүү зорилтын хүрээнд дор дурьдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1. Шинээр төрийн захиргааны албанд томилогдох албан хаагчдыг ажлын байрны чиг үүргийн дагуу төрийн захиргааны мэргэшүүлэх сургалтанд хамруулна.
2. Албан хаагчдийг салбарын чиглэлээр Мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулна.
3. Ажлын байран дээрх сургалтыг хэрэгжүүлэх замаар залуу боловсон хүчнийг ажлын арга барилд сурган дадлагажуулна.
4. Боловсон хүчнийг сонгон шалгаруулахад мэдлэг мэргэжил, ажлын туршлага зэрэг үзүүлэлтүүдийг тууштай харгалзан үзнэ.
5. Энэхүү зорилтын хүрээнд дор дурьдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Өмчлөлийн зорилт 3. Мэдээллийн гадаад дотоод сүлжээний найдвартай байдлыг хангах, түүний ашиглалтыг сайжруулна.

Энэхүү зорилтын хүрээнд дор дурьдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагаанд ерөнхий хяналт тавина
2. Төрийн албанд цаас хэргэлэх явдлыг багасгах зорилгоор “e-Office” системийг ашиглана
3. Мэдээллийн гадаад сүлжээний хурдыг нэмэгдүүлэх арга замыг судалж боломжит арга хэмжээг авна.

Өмчлөлийн зорилт 4. Ажиллагсадыг ажиллах нөхцөлөөр хангах

Энэхүү зорилтын хүрээнд дор дурьдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1. Дасгалжуулагч, арга зүйчдийн ажлын байрны чиг үүргийн давхардал, ачаалалыг судалж зарим ажилтны ажлын байрны тодорхойлолтонд өөрчлөлт оруулна
2. Ажлын байрны эрүүл ахуйн нөхцлийг тодорхойлж шаардлагатай арга хэмжээ авна.
3. Цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулна.

6.4.НӨӨЦИЙН АШИГЛАЛТ САЙЖРУУЛАЛТ:

БТСГ өмчлөлийн зорилтыг хэрэгжүүлэхдээ одоо байгаа ажиллах хүчний санхүү болон санхүүгийн нөөцийн ашиглалт үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх, шинээр нөөц бий болгох асуудлыг дор дурьдсан байдлаар хэрэгжүүлэх болно.

Боловсон хүчний бодлого:

а/. Ажилтан сонгон шалгаруулах талаар

Төрийн албанд мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшлийн бэлтгэл ур чадвар, туршлага бүхий боловсон хүчнээр хангах нөхцлийг бүрдүүлэх үүднээс БТСГ-т ажилтан сонгон

шалгаруулж авахдаа шудрага, нээлттэй, ил тод, адил тэгш хандах, өрсөлдүүлэн шалгаруулах зарчимуудыг баримтлана.

б/. Боловсон хүчнийг чадваржуулах талаар:

БТСГ албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх арга хэмжээг дараах хэлбэрээр зохион байгуулна.

- Салбарын хэмжээнд төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр боловсруулах
- Салбарын чиглэлээр албан хаагчдын мэргэжлийн түвшинг дээшлүүлэх талаар урт, дунд, богино хугацааны гадаад, дотоодын сургалтанд хамруулах ажлыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах
- Ажлын байранд нь сургаж дадлагажуулах ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу дараах хэлбэрээр зохион байгуулна
- Тодорхой асуудлаар үүрэг даалгавар өгөх
- Ажлын байрны чиг үүргийн дагуу сургалт семинарт хичээл заах, асуудал боловсруулах, эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавих, БТСГ-ын албан хаагчдыг төрийн захиргааны болон салбарын чиглэлээр мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх чиглэл
 - Хүний нөөцийн удирдлага
 - Төрийн захиргааны удирдлага /бодлого стратеги боловсруулах гэх мэт/
 - Хяналт шинжилгээ үнэлгээ
 - Хэлний сургалт

6.4.2. Санхүүгийн нөөц

БТСГ-нь 2017-2020 оны хугацаанд хүрэхээр дэвшүүлж буй стратегийн зорилтоо хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн нийлүүлэх арга хэмжээний хэрэгжилтээ хангах зорилгоор урсгал зардалд нийт 2.616.5 сая төгрөг, хөрөнгө оруулалтад 2.253.0 сая төгрөг гэж төсөвлөлөө. Урсгал төсөвт төгрөгийг элэгдэлийн зардалд багтаагүй болно. Нийт зардлын 89.5 хувь нь газрын урсгал зардалд 10.5 хувь нь БТС-ын төвлөрсөн арга хэмжээний зардалд хамаарагдах болно. Энэхүү үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд зөвхөн БТСГ-ын нийлүүлэх бүтээгдэхүүн түүний өртөгийг оруулсан болно.

6.5. Эрсдэл

Өмчлөгч байгууллагад учирч болох эрсдэлд /санхүүгийн болоод бусад эерэг ба сөрөг/ мөн нэгэн адил анхааралтай хандах ёстой. Эрсдэл хэд хэдэн замаар өөрөө өөрийгөө тодорхойлж байдаг. Өмчлөлийн зорилтыг тодорхойлох үүднээс эрсдлийг дараах категоруудад бүлэглэж болно. Үүнд:

- 6.5.1. **Болзошгүй өр төлбөр:** Төлөвлөсөн санхүүгийн тайланг бэлтгэн танилцуулж байгаа энэ үед БТСГ ирээдүйд төлбөр хийх хариуцлагыг бий болгох ямар нэгэн материаллаг нөлөө бүхий болзошгүй үйл явдал байхгүй байна.
- 6.5.2. **Хуувь эрхийн актийн үйлчлэлтэй холбоотой эрсдэл:** БТСГ үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд эрх зүйн зохицуулалтын хувьд ямар нэгэн эрсдэл гаргахгүй гэж үзэж байна.

- 6.5.3. **Өмчлөлийн өөрчлөлт:** БТСГ нь МУ-ын ЗГ-ын БТС-ын тухай хуульд зааснаар БТС-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тул өмчлөлийн хувьд өөрчлөлт гаргахгүй болно.
- 6.5.4. **Бодлогын өөрчлөлт:** МУ-ын Засгийн газрын 2016 оны 09-р тогтоолын дагуу БТСГ үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд бүтэц зохион байгуулалтыг өөрчлөхөөр санал боловсруулж байгаа хэдий ч байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон бодлогын шинжтэй өөрчлөлт гарахгүй гэж тооцов.
- 6.5.5. **Орцын зах зээл:** Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг байгуулахад тус газрын ажиллах хүчин санхүүгийн болон материаллаг нөөц үндсэндээ хангагдсан боловч төсөв хүрэлцэхгүй эрсдэл гарч болохгүй юм.
- 6.5.6. **Хөрөнгийн алдагдал:** Үйл ажиллагаанд ашиглагдах хөрөнгийн хувьд зөвхөн тээврийн хэрэгсэлийн төгрөгийг даатгалын зардлыг тусгасан бөгөөд бусад хөрөнгийн хувьд даатгал хийгдээгүй үүнээс учирч болох хөрөнгийн алдагдлийг тооцож төсөвт тусгаагүй болно.